



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 4/2022

Мандалговь

Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна  
фасад, дээврийн засвар, Д.Чагдаржавын талбайн  
тохижилтын зураг, төсөв хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна фасад, дээврийн засвар”, Д.Чагдаржавын талбайн тохижилтын зураг, төсөв хүлээн авах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Баатардорж (Засаг даргын Тамгын газрын нярав)

Н.Энхмарт (Засаг даргын Тамгын газрын нягтлан)

Г.Жамбалсүрэн (Люкс товер ХХК-ийн архитектор)

Нарийн бичгийн дарга:

С.Ариунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. “Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна фасад, дээврийн засвар”, Д.Чагдаржавын талбайн тохижилтын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Энхмэнд)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150475